



ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 5/50

Чингис хот

С.Оюун-Эрдэнийг түр орлон  
гүйцэтгэгчээр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3, 43.3.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал, байгууллагын өргөдөл, гомдол, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн С.Оюун-Эрдэнийг 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн Нутгийн захиргааны байгууллагын бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.
2. С.Оюун-Эрдэнэд Нутгийн захиргааны байгууллагын бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг тооцож олгохыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д зөвшөөрсүгэй.
3. Нутгийн захиргааны байгууллагын бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг С.Оюун-Эрдэнэд үүрэг болгосугай.
4. С.Оюун-Эрдэнэд томилогдоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ж.Гантулга/-т гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

\* 231030171